



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 376

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаах авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хот хөдөөгийн сэргэлт” бодлогын хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй “Нийтийн тээврийн автопарк”, “Нийтийн тээврийн автобус” төслийн хүрээнд худалдан авсан 757 нэрийн нийт 259,329,767,400.00 (хоёр зуун тавин есөн тэрбум гурван зуун хорин есөн сая долоон зуун жаран долоон мянга дөрвөн зуун) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг нийслэлийн өмчид, 24 нэрийн нийт 12,817,245,600.00 (арван хоёр тэрбум найман зуун арван долоон сая хоёр зуун дөчин таван мянга зургаан зуун) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг Дархан-Уул аймгийн өмчид тус тус хавсралтад заасны дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны нарийн бичгийн дарга Д.Сумъяабазар, Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал, Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга Ч.Сайханбаяр, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Баасанжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэл, аймагт бий болсон үндсэн хөрөнгийг санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль, тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

A red official stamp is located in the center of the page. It contains Mongolian text and a circular emblem. A handwritten signature in black ink is written over the stamp and extends to the right. A horizontal line is drawn across the stamp and signature area.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны...7 дугаар сарын 7-ны өдрийн  
376 дугаар тогтоолын хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ  
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

1.Нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгө

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон огноо	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүртгэх нийт үнэ
					(төгрөг)
1	Их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй автобус	2023	70	625,493,880.00	43,784,571,600.00
2	Их багтаамжийн дизель хөдөлгүүртэй автобус	2023	600	336,283,698.00	201,770,218,800.00
3	Дунд багтаамжийн дизель хөдөлгүүртэй автобус	2023	50	218,636,460.00	10,931,823,000.00
4	Цахилгаан автобусны цэнэглэх төхөөрөмж	2023	37	76,842,000.00	2,843,154,000.00
<b>Нийслэлийн өмчид бүртгэх нийт дүн</b>					<b>259,329,767,400.00</b>

2.Дархан-Уул аймгийн өмчид бүртгэх хөрөнгө

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон огноо	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүртгэх нийт үнэ
					(төгрөг)
1	Их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй автобус	2023	20	625,493,880.00	12,509,877,600.00
2	Цахилгаан автобусны цэнэглэх төхөөрөмж	2023	4	76,842,000.00	307,368,000.00
<b>Дархан-Уул аймгийн өмчид бүртгэх нийт дүн</b>					<b>12,817,245,600.00</b>
					<b>272,147,013,000.00</b>
<b>Нийт дүн</b>					<b>(хоёр зуун далан хоёр тэрбум нэг зуун дөчин долоон сая арван гурван мянга)</b>